АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Өндөр-Улаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: АРА-2026/124/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.open.audit.mn<br>Архангай аймаг<br>2026 он | Дарга,Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа<br>Утас:7033-3141<br>Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn<br><br>Аудитын менежер Д.Нэргүйбаатар<br>Утас: 7033-2860<br>Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn<br><br>Аудитор С.Оргил<br>Утас: 99197346<br>Цахим хаяг: Info@shinjlenmagadlakhui-audit.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2026.02.25 № 78
танай ____________-ны №____________-т

АРХАНГАЙ АЙМГИЙН ӨНДӨР-УЛААН СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Т.ЗОРИГТБААТАР ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасны дагуу Архангай аймгийн Өндөр-Улаан сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Аудитын гол асуудал**

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх Ерөнхий боловсрол хөтөлбөрийн хүрээнд 15 арга хэмжээг хэрэгжүүлэхээр 3,391,628.8 мянган төгрөгийн санхүүжилт авч, гүйцэтгэлээр 3,309,986.1 мянган төгрөгийг зарцуулж, 81,642.7 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

**Бусад асуудлын хэсэг**

Тус байгууллага нь 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 6 үндсэн зорилтын хүрээнд 20 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Т.БАЙГАЛМАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* /төгрөгөөр/

| Код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 403,383,887.25 | 210,695,680.40 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 270,765,022.41 | 81,642,730.96 |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 270,765,022.41 | 81,642,730.96 |
| 3121 | Төгрөг | 270,765,022.41 | 81,642,730.96 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 270,765,022.41 | 81,642,730.96 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 132,618,864.84 | 129,052,949.44 |
| 351 | Түүхий эд материал | 800,000.00 | 800,000.00 |
| 35130 | Эм боох материал | 800,000.00 | 800,000.00 |
| 354 | Хангамжийн материал | 131,818,864.84 | 128,252,949.44 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 89,200.00 | 89,200.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 109,724,758.36 | 92,441,550.36 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 900.00 | - |
| 35450 | Барилгын засварын материал | 895,000.00 | 585,000.00 |
| 35460 | Хүнсний материал | - | 125,100.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 21,109,006.48 | 35,012,099.08 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 2,715,048,673.31 | 3,037,654,078.89 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 2,715,048,673.31 | 3,037,654,078.89 |
| 392 | Биет хөрөнгө | 2,637,736,339.73 | 2,960,841,745.23 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 2,835,453,138.42 | 3,162,453,138.42 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (583,534,047.89) | (683,507,563.52) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 335,648,837.12 | 386,224,145.12 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (111,239,306.39) | (134,311,413.04) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 135,449,058.92 | 192,101,041.24 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (71,657,934.08) | (57,111,546.45) |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | 60,000,000.00 | 61,600,000.00 |
| 39210 | Хуримтлагдсан элэгдэл | (500,000.00) | (6,513,333.33) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 17,060,954.00 | 17,060,954.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (5,690,572.11) | (6,597,619.83) |
| 39217 | Ном | 26,746,211.74 | 29,443,942.62 |
| 393 | Биет бус хөрөнгө | 77,312,333.58 | 76,812,333.66 |
| 39301 | Програм хангамж | 1,500,000.00 | 1,500,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (41,666.42) | (541,666.34) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 75,854,000.00 | 75,854,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 3,118,432,560.56 | 3,248,349,759.29 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 3,118,432,560.56 | 3,248,349,759.29 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 3,118,432,560.56 | 3,248,349,759.29 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 633,067,002.12 | 633,067,002.12 |
| 511002 | Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө | 633,067,002.12 | 633,067,002.12 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 1,406,056,112.19 | 1,535,973,310.92 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 1,406,056,112.19 | 1,406,056,112.19 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 129,917,198.73 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 1,079,309,446.25 | 1,079,309,446.25 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 3,118,432,560.56 | 3,248,349,759.29 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 3,178,109,452.40 | 3,600,334,638.48 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 292,572,752.40 | 484,565,138.48 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 292,572,752.40 | 484,565,138.48 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 5,691,200.00 | 5,094,300.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 5,431,200.00 | 4,604,300.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 260,000.00 | 490,000.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 281,355,592.30 | 465,497,745.88 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 5,525,960.10 | 13,903,092.60 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 2,885,536,700.00 | 3,115,769,500.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 2,663,236,700.00 | 3,003,309,900.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 2,663,236,700.00 | 3,003,309,900.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 222,300,000.00 | 112,459,600.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 222,300,000.00 | 112,459,600.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 2,830,111,753.04 | 3,452,067,439.75 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 2,830,111,753.04 | 3,452,067,439.75 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 2,735,170,592.04 | 3,285,342,939.75 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,982,966,911.10 | 2,405,786,877.61 |
| 210101 | Үндсэн цалин | 1,286,846,519.00 | 1,444,831,725.33 |
| 210102 | Нэмэгдэл | 591,026,061.10 | 773,046,015.00 |
| 210104 | Урамшуулал | 105,094,331.00 | 187,909,137.28 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 247,150,220.30 | 299,382,473.84 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 167,807,529.98 | 202,284,130.31 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 19,847,939.88 | 24,064,522.43 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 12,360,638.80 | 15,056,750.20 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 9,403,824.03 | 11,595,375.20 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 37,730,287.61 | 46,381,695.70 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 103,198,089.00 | 104,959,600.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 31,035,755.00 | 48,924,144.00 |
| 210302 | Түлш, халаалт | 71,549,834.00 | 56,035,456.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 612,500.00 | - |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 6,718,400.00 | 17,320,858.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 6,718,400.00 | 10,164,150.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | - | 7,156,708.00 |
| 2105 | Нормативт зардал | 107,140,900.00 | 155,348,100.00 |
| 210502 | Хоол, хүнс | 107,140,900.00 | 155,348,100.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 4,281,500.00 | 1,156,200.00 |
| 210604 | Урсгал засвар | 4,281,500.00 | 1,156,200.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 13,868,490.66 | 30,511,973.86 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 5,431,200.00 | 4,604,300.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 8,437,290.66 | 25,907,673.86 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 269,846,080.98 | 270,876,856.44 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 70,434,626.45 | 54,995,063.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 18,653,500.00 | 15,821,153.14 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 180,757,954.53 | 200,060,640.30 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 94,941,161.00 | 166,724,500.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 94,939,200.00 | 166,654,500.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 83,902,500.00 | 121,737,500.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 11,036,700.00 | 44,917,000.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 1,961.00 | 70,000.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,961.00 | 70,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | 347,997,699.36 | 148,267,198.73 |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | - | 18,350,000.00 |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | - | 18,350,000.00 |
| 4 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | - | (18,350,000.00) |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | 347,997,699.36 | 129,917,198.73 |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 2,891,227,900.00 | 3,120,863,800.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 5,691,200.00 | 5,094,300.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 5,691,200.00 | 5,094,300.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 5,691,200.00 | 5,094,300.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 5,431,200.00 | 4,604,300.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 260,000.00 | 490,000.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 2,885,536,700.00 | 3,115,769,500.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 2,663,236,700.00 | 3,003,309,900.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 2,663,236,700.00 | 3,003,309,900.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 222,300,000.00 | 112,459,600.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 222,300,000.00 | 112,459,600.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 2,648,509,917.59 | 3,245,237,791.45 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 2,648,509,917.59 | 3,245,237,791.45 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 2,558,153,456.59 | 3,078,514,191.45 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,984,401,228.26 | 2,405,786,874.61 |
| 210101 | Үндсэн цалин | 1,252,195,928.26 | 1,444,831,722.33 |
| 210102 | Нэмэгдэл | 627,879,600.00 | 773,046,015.00 |
| 210104 | Урамшуулал | 104,325,700.00 | 187,909,137.28 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 245,473,722.22 | 299,382,476.84 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 164,854,591.91 | 202,284,130.31 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 20,063,804.19 | 24,064,522.43 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 10,624,832.43 | 15,056,753.20 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 9,976,514.09 | 11,595,375.20 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 39,953,979.60 | 46,381,695.70 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 103,298,039.00 | 104,959,600.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 33,696,915.00 | 48,924,144.00 |
| 210302 | Түлш, халаалт | 68,988,624.00 | 56,035,456.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 612,500.00 | - |
| 2105 | Нормативт зардал | 105,029,700.00 | 155,473,200.00 |
| 210502 | Хоол, хүнс | 105,029,700.00 | 155,473,200.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 6,027,410.00 | 7,500,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 6,027,410.00 | 7,500,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 29,216,542.01 | 35,991,800.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 5,431,200.00 | 4,604,300.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 23,785,342.01 | 31,387,500.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 84,706,815.10 | 69,420,240.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 64,274,515.10 | 54,248,140.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 20,432,300.00 | 15,172,100.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 90,356,461.00 | 166,723,600.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 90,354,500.00 | 166,653,600.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 79,317,800.00 | 121,736,600.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 11,036,700.00 | 44,917,000.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 1,961.00 | 70,000.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,961.00 | 70,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | 242,717,982.41 | (124,373,991.45) |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 177,772,390.00 | 64,818,300.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 177,772,390.00 | 64,818,300.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 177,772,390.00 | 64,818,300.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 177,772,390.00 | 64,818,300.00 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | (177,772,390.00) | (64,818,300.00) |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | 64,945,592.41 | (189,192,291.45) |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 270,765,022.41 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 270,765,022.41 | 81,642,730.96 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* /төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 633,067,002.12 | 1,079,309,446.25 | 1,058,058,412.83 | 2,770,434,861.20 |
| 2 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 633,067,002.12 | 1,079,309,446.25 | 1,058,058,412.83 | 2,770,434,861.20 |
| 3 | Тайлант үеийн үр дүн | | | 347,997,699.36 | 347,997,699.36 |
| 4 | 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 633,067,002.12 | 1,079,309,446.25 | 1,406,056,112.19 | 3,118,432,560.56 |
| 5 | 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 633,067,002.12 | 1,079,309,446.25 | 1,406,056,112.19 | 3,118,432,560.56 |
| 6 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 633,067,002.12 | 1,079,309,446.25 | 1,406,056,112.19 | 3,118,432,560.56 |
| 7 | Тайлант үеийн үр дүн | | | 129,917,198.73 | 129,917,198.73 |
| 8 | 2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 633,067,002.12 | 1,079,309,446.25 | 1,535,973,310.92 | 3,248,349,759.29 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*
/төгрөгөөр/

| Д/Д | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү дүн | Хувь |
|---|---|---|---|---|---|
| 1 | ТАТААС, САНХҮҮЖИЛТЫН ОРЛОГО | 3,163,286,500.00 | 3,115,769,500.00 | 47,517,000.00 | 98.5 |
| 131 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 3,050,826,900.00 | 3,003,309,900.00 | 47,517,000.00 | 98.44 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 3,050,826,900.00 | 3,003,309,900.00 | 47,517,000.00 | 98.44 |
| 132 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 112,459,600.00 | 112,459,600.00 | | 100 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 112,459,600.00 | 112,459,600.00 | | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 120004 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 271,434,400.00 | 5,094,300.00 | 266,340,100.00 | 1.88 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 4,604,300.00 | 4,604,300.00 | | 100 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 490,000.00 | 490,000.00 | | 100 |
| 1200043 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 266,340,100.00 | | 266,340,100.00 | |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 3,434,720,900.00 | 3,120,863,800.00 | 313,857,100.00 | 90.86 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 3,434,720,900.00 | 3,309,986,091.45 | 124,734,808.55 | 96.37 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 3,264,374,900.00 | 3,143,332,491.45 | 121,042,408.55 | 96.29 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 2,511,920,200.00 | 2,405,786,874.61 | 106,133,325.39 | 95.77 |
| 210101 | Үндсэн цалин | 1,553,414,600.00 | 1,444,831,722.33 | 108,582,877.67 | 93.01 |
| 210102 | Нэмэгдэл | 876,936,800.00 | 773,046,015.00 | 103,890,785.00 | 88.15 |
| 210104 | Урамшуулал | 81,568,800.00 | 187,909,137.28 | - 106,340,337.28 | 230.37 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 312,859,400.00 | 299,382,476.84 | 13,476,923.16 | 95.69 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 212,382,800.00 | 202,284,130.31 | 10,098,669.69 | 95.25 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 25,119,200.00 | 24,064,522.43 | 1,054,677.57 | 95.8 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 12,559,500.00 | 15,056,753.20 | -2,497,253.20 | 119.88 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 12,559,500.00 | 11,595,375.20 | 964,124.80 | 92.32 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 50,238,400.00 | 46,381,695.70 | 3,856,704.30 | 92.32 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 104,959,600.00 | 104,959,600.00 | | 100 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 52,509,600.00 | 48,924,144.00 | 3,585,456.00 | 93.17 |
| 210302 | Түлш, халаалт | 50,650,000.00 | 56,035,456.00 | -5,385,456.00 | 110.63 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,800,000.00 | | 1,800,000.00 | |
| 2105 | Нормативт зардал | 155,478,100.00 | 155,473,200.00 | 4,900.00 | 100 |
| 210502 | Хоол, хүнс | 155,478,100.00 | 155,473,200.00 | 4,900.00 | 100 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 7,500,000.00 | 7,500,000.00 | | 100 |
| 210604 | Урсгал засвар | 7,500,000.00 | 7,500,000.00 | | 100 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 43,717,500.00 | 42,921,800.00 | 795,700.00 | 98.18 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 4,604,300.00 | 4,604,300.00 | | 100 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 39,113,200.00 | 38,317,500.00 | 795,700.00 | 97.97 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 127,940,100.00 | 127,308,540.00 | 631,560.00 | 99.51 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 112,768,000.00 | 112,136,440.00 | 631,560.00 | 99.44 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 15,172,100.00 | 15,172,100.00 | | 100 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 170,346,000.00 | 166,653,600.00 | 3,692,400.00 | 97.83 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 170,346,000.00 | 166,653,600.00 | 3,692,400.00 | 97.83 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 125,429,000.00 | 121,736,600.00 | 3,692,400.00 | 97.06 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 44,917,000.00 | 44,917,000.00 | | 100 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН | 3,434,720,900.00 | 3,309,986,091.45 | 124,734,808.55 | 96.37 |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 270,765,022.41 | - 270,765,022.41 | |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 81,642,730.96 | -81,642,730.96 | |
| 3 | Төсвийн байгууллага | 1 | 1 | | 100 |
| 5 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | | | | |
| 6 | Удирдах ажилтан | 3 | 3 | | 100 |
| 7 | Гүйцэтгэх ажилтан | 46 | 46 | | 100 |
| 8 | Үйлчлэх ажилтан | 34 | 34 | | 100 |
| 12 | Төрийн өмчит ЕБС | 817 | 795 | 22 | 97.31 |
| 28 | СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД) | 49 | 49 | | 100 |
| 31 | Мэргэжлийн боловсролын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮМБ) | 2 | 2 | | 100 |
| 32 | Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ) | 1 | 1 | | 100 |
| 33 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 31 | 31 | | 100 |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа[1] илрээгүй, залруулаагүй 4,863.7 мянган төгрөгийн зөрчил[2] илэрч 1 албан шаардлага, 1 зөвлөмж, 1 төлбөрийн акт хүргүүллээ.

Аудитаар залруулагдаагүй 1 зөрчилтэй асуудлын материаллаг зөрчил нь 4,863.7 мянган төгрөг бөгөөд гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн 36,937.3 мянган төгрөгөөс бага байгаа тул "**Өөрчлөлтгүй" дүгнэлт** өглөө.

### 3.1 Албан шаардлага

3.1.1 Тайлант онд төсвийн 4,593,400 төгрөгийн хөрөнгөөр худалдан авалтыг цахим дэлгүүрээс аваагүй, бусад этгээдээс худалдан авсан байна.

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-т "Улс, орон нутгийн төсөв болон захиалагчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад энэ хуулийг дагаж мөрдөнө", 4 дүгээр зүйлийн 4.1.8-д "ерөнхий гэрээний арга" гэж захиалагчийн тодорхой хугацаанд давтамжтай худалдан авдаг, эсхүл байнгын хэрэгцээтэй бараа, үйлчилгээний нэгж дээд үнэ болон бусад нөхцөлийг тогтоосон ерөнхий гэрээг нэг ба түүнээс дээш оролцогчтой байгуулж, цахим дэлгүүрээс бараа, үйлчилгээ худалдан авахыг"; 9 дүгээр зүйлийн 9.1-т "Хуульд өөрөөр заагаагүй бол худалдан авах ажиллагааг зохион байгуулах, мэдээлэл солилцох, мэдээллийн ил тод байдлыг хангах ажиллагааг цахим системээр гүйцэтгэнэ", 38 дугаар зүйлийн 38.1-т "Ерөнхий гэрээний аргын хоёрдугаар үе шатанд захиалагч худалдан авах бараа, үйлчилгээний тоо хэмжээ, хүргэх газар, хуваарь бүхий захиалгын хуудсыг цахим системд илгээж, үнийн санал дуудаж цахим дэлгүүрээс худалдан авна" -г зөрчсөн байна.

*Шийдвэрлэсэн нь*: Зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх.

*Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.*

## 4. Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөгөөр)

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Цахим худалдан авалттай холбоотой | 1 | 4,593.4 | | | 1 | 4,593.4 | | | | | | |
| **Дүн** | **1** | **4.59364** | | | 1 | 4,593.4 | | | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | |
| Архангай аймгийн Архангай аймгийн Өндөр-Улаан сумын Ерөнхий боловсролын сургууль нь тайлант хугацаанд шилэн дансанд оруулбал зохих 171 мэдээллээс 168 мэдээллийг хугацаанд байршуулж, 3 мэдээлэл хугацаа хоцроон байршуулж ажилласан байна. | 1 | - | | | 1 | - |
| Дүн | 1 | - | | | 1 | - |